



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/273

Сүхбаатар сум

Коронавируст халдвараар өвчилсөн иргэдийн
эдгэсний дараах үзлэг оношилгоо зохион
байгуулж, урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.5, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэдийн хүсэлтийн дагуу Улсын "Нэгдсэн 3-р эмнэлэг"-ийн дурангийн их эмч Д.Мөнх-Эрдэнэ, Зүрх судасны их эмч Л.Бямбацогт, Эрчимт эмчилгээний их эмч О.Мөнхбат нарын багтай хамтран Коронавируст халдвараар өвдсөн иргэдэд эдгэрэлтийн дараах үзлэг оношилгоог 2021 оны 09 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч /Б.Энхбат/-д даалгасугай

2.Улсын Нэгдсэн 3-р эмнэлгийн эмч нарт олгох урамшууллын зардлыг хавсралтаар баталсугай.

3.Зардалд 5'000'000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА Ш.ОРГИЛ

430810721

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дугаар сарын 16 -ний өдрийн
А/223 тоот захирамжийн хавсралт

Коронавируст халдварын дараах үзлэг оношлогоо хийх
Улсын нэгдсэн 3-р эмнэлгийн эмч нарын багийн зардал

2021.09.16

№	Зардал	Нэгж үнэ	Тайлбар	Нийт үнэ
1	Зочид буудлын зардал	3 ортой өрөө 100000	5 өдөр байрлана	500'000
2	Эмч нарын унаа, хоол, урамшуулал	Өдрийн хөлс 1500000	3 өдөр ажиллана	4'500'000
	НИЙТ ДҮН			5'000'000

Төсөв гаргасан:

/НБХ-ийн мэргэжилтэн/

Т.Мягмарцэнд

Төсөв хянасан:

/Төсвийн зарлагын мэргэжилтэн/

Ж.Хишигдэлгэр